

НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХОО ИЛЭРХИЙЛЖ, БҮРТГҮҮЛЭХ

Сонгууль товлон зарлахаас өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох эрхтэй. Эвсэлд нэгдсэн нам тус бүр дээрх шаардлагыг хангасан байна.

Нам, эвсэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай хүсэлтээ **санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө** Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.
/МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйл/

НАМ

1. Сонгуульд оролцох тухай намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын шийдвэр;
2. Намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
3. Намын улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар;
4. Сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;
6. Хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам;
7. 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;
8. Намын сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;
9. Намыг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах 3 хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нь нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг.

ЭВСЭЛ

1. Сонгуульд оролцох тухай эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэр;
2. Эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний хуулбар;
3. Эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн Улсын дээд шүүхээр баталгаажуулсан хуулбар;
4. Эвслийг төлөөлөх байгууллагаар батлагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;
6. Хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх эвслийн дотоод журам;
7. 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нам тус бүрд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;
8. Эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;
9. Эвслийг төлөөлж Сонгуулийн ерөнхий хороотой харилцах 3 хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нь нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг;
10. Эвслийн гэрээний хуулбар;
11. Эвсэл байгуулах тухай нам тус бүрийн шийдвэр.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Нам, эвслээс ирүүлсэн баримт бичгийг нягтлан шалгаад, хүлээн авснаас хойш **5 хоногт багтаан** сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.